



**ИРГЭНИЙ НИСЭХИЙН
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ**

2016 оны 05 сарын 19 өдөр

Дугаар A/349

Улаанбаатар хот

**Иргэний нисэхийн багц дүрмийн
бүртгэлийн дэвтрүүд батлах тухай**

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3.2 дахь заалт, 8.4 дэх хэсэг, Иргэний нисэхийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2, 8.4.1, 8.4.4 дэх заалт, 11 дүгээр зүйлийн 11.1, 14 дүгээр зүйлийн 14.1 дэх хэсэг, Засгийн газрын 2015 оны 6 дугаар сарын 22-ны өдрийн Дүрэм батлах тухай 258 дугаар тогтоолоор батлагдсан “Иргэний нисэхийн ерөнхий газрын дүрэм”-ийн 2.1.5, 2.1.7, 3.5.7, 3.6.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:


1. Төрөөс иргэний нисэхийн салбарт 2020 он хүртэл баримтлах бодлогын 2.1.2. дахь заалт, Иргэний нисэхийн ерөнхий газрын даргын 2015 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн “Дүрмийн боловсруулалтын талаар авах арга хэмжээний тухай” А/791 дүгээр тушаалыг хэрэгжүүлэх, иргэний нисэхийн аюулгүй ажиллагаа, аюулгүй байдлыг хангах зорилгоор Aircraft Logbook (CAA 2101) /Агаарын хөлгийн бүртгэлийн дэвтэр/-ийг нэгдүгээр хавсралтаар, AD Logbook (CAA 1464) /Нислэгт тэнцэх чадварын удирдамжийн бүртгэлийн дэвтэр/-ийг хоёрдугаар хавсралтаар, Engine Logbook (CAA 2158) /Хөдөлгүүрийн бүртгэлийн дэвтэр/-ийг гуравдугаар хавсралтаар, Propeller Logbook (CAA 2110) /Сэнсний бүртгэлийн дэвтэр/-ийг дөрөвдүгээр хавсралтаар, Pilot Logbook /Нисгэгчийн бүртгэлийн дэвтэр/-ийг тавдугаар хавсралтаар, Maintenance Record Sheet (CAA 400) /Засвар үйлчилгээний бүртгэлийн дэвтэр/-ийг зургаадугаар хавсралтаар, TechnicalLog (CAA 006) /Техникийн бүртгэлийн дэвтэр/-ийг долоодугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Бүртгэлийн дэвтрүүдийг хэвлүүлэх зардлыг холбогдох төсвөөс гаргахыг Санхүү, эдийн засгийн газар /А.Дагвадорж/-т, үйл ажиллагаандаа мөрдөж ажиллах ажлыг зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг Орлогч дарга бөгөөд Нисэхийн аюулгүй ажиллагааны хяналт, зохицуулалтын газар /Д.Батчулуун/, Дүрмийн боловсруулалтын хэлтэс /Ё.Энхтөр/-т тус тус үүрэг болгосугай.

3. Энэ тушаал гарсантай холбогдуулан Иргэний нисэхийн ерөнхий газрын даргын 2002 оны “Нислэгийн дэвтрийн загвар батлах тухай” 105 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ

Г.НЯМДАВАА



08 0875